



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/99

Зуунмод

“Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 103 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 103 жилийн ойг угтан орон нутагт Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, ахмад дайчдын алдар гавьяаг алдаршуулах, иргэд хүүхэд залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 26-аас 03 дугаар сарын 15-ны өдрүүдэд тусгай төлөвлөгөөний дагуу ойн арга хэмжээ зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Баярын арга хэмжээнд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. 2024 оны “Залуучуудын манлайлал-Гэр бүлийн хөгжлийн дэмжих” урианы жилийн хүрээнд Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 103 жилийн ой, Монгол цэргийн өдрийн баярыг угтаж Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран урлаг, спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгуулах, ард иргэд хүүхэд залуучуудад сурталчилж, төлөвлөгөөний дагуу зохион явуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (Дэд хурандаа Т.Төмөрчөдөр)-д үүрэг болгосугай.

4. “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 103 жилийн ойн баярын нэгдсэн арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн тоог Мөнх-Алдарын талбайд зохион байгуулж явуулахыг Зуунмод цэргийн хүрээний дарга, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагч (Хурандаа Ж.Мөнхбаяр)-д зөвшөөрсүгэй.

5. Баярын хүндэтгэлийн тоглолтыг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран зохион явуулахыг Монгол туургатан театрын захирал (Д.Намсрайноров), Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (Дэд хурандаа Т.Төмөрчөдөр) нарт тус тус хариуцуулсугай.

6. Үйл ажиллагаанд шаардагдах 4,072,500 (дөрвөн сая далан хоёр мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА




Д.МӨНХБААТАР

4104010214

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 19 -ны өдрийн А/99 дүгээр захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ МАРШ - ТУСГАЙ
БЭЛТГЭЛИЙН АВАРГА ТАСАГ ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Тэмцээний төрөл	Байр	Өргөмжлөл	Тоо ширхэг	Нэг бүрийн (үнэ)	Мөнгөн шагнал (үнэ)	Бүгд үнэ	
Нэг. Хугацаат цэргийн алба хаагчдын тэмцээн								
1	ХЦАХ-дын дунд дунд танин мэдэхүй, спортын нөхөрсөг 3 төрөлт тэмцээний зардал	Буухиа	Өргөмжлөл	3 ш	2500	-	7500	
2		Гар бөмбөг	Өргөмжлөл	3 ш	2500	-	7500	
3		АХА тэмцээн	Өргөмжлөл	3 ш	2500	-	7500	
4		Багийн нийлбэр дүнгээр 1-р байр	Өргөмжлөл	1 ш	20,000	150,000	170,000	
5		Багийн нийлбэр дүнгээр 2-р байр	Өргөмжлөл	1 ш	20,000	100,000	120,000	
6		Багийн нийлбэр дүнгээр 3-р байр	Өргөмжлөл	1 ш	20,000	80,000	100,000	
7		Алт, мөнгө, хүрэл медаль			39 ш	10,000	-	390,000
8		Цом			1 ш	40,000	-	40,000
Дүн							842,500	
Хоёр. Мөрдэс гоёсон бүсгүй тэмцээн								
9	Мөрдэс гоёсон бүсгүй тэмцээн	1-р байр	Өргөмжлөл	1 ш	40,000	250,000	290,000	
10		2-р байр	Өргөмжлөл	1 ш	40,000	200,000	240,000	
11		3-р байр	Өргөмжлөл	1 ш	40,000	150,000	190,000	
12	Тэмцээний шүүгчдийн зардал			4 ш		80,000	320,000	
Дүн							1,040,000	
Гурав. Бусад								
13	Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойг угтсан Цэргийн албыг сурталчилсан "БИ ЭХ ОРНЫ ХҮҮ" телевизийн нэвтрүүлэг (контент) хийхэд шаардагдах төсөв.					500,000	500,000	
14	Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойг угтсан арга хэмжээний материал хэрэгсэл, бусад зардал					-	540,000	
15	"Эх оронч үзэл" бидний бахархал сэдэвт сургалтын багшийн хөлс					3x50,000	150,000	
Дүн							1,190,000	
Дөрөв. Монгол цэргийн өдрийн хүндэтгэлийн арга хэмжээ								
Хүний тоо					Нэг бүрийн үнэ		Бүгд үнэ	
40					25,000		1,000,000	
Дөрөв. Нийт дүн							4,072,500	

ТӨСӨВ ЗОХИОСОН:
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА
ДЭД ХУРАНДАА  Т.ТӨМӨРЧӨДӨР

ХЯНАСАН:
САНХҮҮ, ТӨРИЙН САЛГАХ, ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН  Ж.ЭРДЭНЭЖАРГАЛ